

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXIX (433)

2015

(73-78)

МОНГОЛ ХҮНИЙ НЭРИЙН САН ДАХЬ ДАЙНЫ УЛ МӨР

Ц. Сувд*

Товчлол: Хорьдугаар зуунд болж өнгөрсөн Дэлхийн II дайнд Зөвлөлтийн улаан арми Германы фашизмыг ялсан, 1939 оны Халх голын дайн, 1945 оны чөлөөлөх дайнд Зөвлөлт, Монголын арми Японы түрэмгийлэгчдийг бут цохисон зэрэг түүхэн үйл явдлууд манай ард түмний сэтгэл зүрхэнд гүн ул мөрөө үлдээсний баримт болсон олон тооны хүний нэр өнөө хүртэл бидний дунд хэрэглэгдсээр байна. Тухайлбал Орос, Орсоо, Сэсээр гэх мэт улс үндэстний нэр; Жуков, Суворов, Ворошилов зэрэг цэргийн жанжны нэр; Солдат, Майор, Генерал, Маршал зэрэг цэргийн албан тушаал, цол хэргэмийн нэр; Танк, Винтов зэрэг зэвсгийн нэр; Отряд Застав, Арми зэрэг цэргийн зохион байгуулалттай холбоотой нэр монгол хүний нэрийн санд орж ирснийг баримттайгаар өгүүлэв. Бас дайны ялалтын дараа энх цаг ирсний бэлгэдэл Ялалт, Бат-Ялалт, Энх, Энхтайван гэх мэтийн олон нэр бий болсон тухай өгүүлнэ.

Түлхүүр үг: хүний нэр, нэрийн сан, дайн, цэрэг арми

Аливаа хэлний үгийн сангийн дотроос тухайн цаг үеийнхээ түүхэн онцлогийг өөртөө тусгаж, хувьсан өөрчлөгдөхдөө хялбар хэсэг бол оноосон нэр, түүний дотор хүний нэр байдаг. Оросын нэр зүйч А.В.Суперанская “Ямар ч нэр тухайн ард түмнийхээ тодорхой соёл-түүхийн нөхцөлд үүсэн бий болдог. Ийм учраас олонх нэр өөртөө тухайн цаг үеийнхээ үйл явдлын тодорхой ул мөрийг хадгалж байдаг”¹ хэмээн бичсэнчлэн өнгөрсөн ХХ зуунд монголын ард түмний туулж ирсэн нийгмийн хөгжлийн үе шат бүхэнд хүний нэр тухайн үеийнхээ түүхийн гол гол үйл явдал, өөрчлөлтийг тусган хадгалсан хэлний бодит баримт болж ирсэн билээ.

Дэлхийн II дайнд Зөвлөлтийн улаан арми Германы фашизмыг ялсан, 1939 оны Халх голын дайн, 1945 оны чөлөөлөх дайнд Зөвлөлт, Монголын арми Японы түрэмгийлэгчдийг бут цохисон зэрэг түүхэн үйл явдлууд манай ард түмний сэтгэл зүрхэнд гүн ул мөрөө үлдээсний баримт болсон олон тооны хүний нэр өнөө хүртэл хэрэглэгдсээр байна. Ялангуяа манай дэлхийн 72 улс орон хамрагдаж, 110 сая хүн дайчлагдан, 55 сая хүний амь нас үрэгдсэн² дэлхийн хоёрдугаар дайн бол хүн төрлөхтний түүхэнд тохиолдсон аймшигт үйл явдал байлаа. Энэ дайны гол хүндийг

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

¹ Суперанская А.В. (1973). Общая теория имени собственного. Москва., стр. 4.

² Монголын нэвтэрхий толь. (2000). Улаанбаатар.

үүрч гарсан Оросын ард түмэн фашист Германыг бут цохиж, аугаа их эх орны дайнд ялалт байгуулсныхаа 70 жилийн ойг энэ жил ёслол тэмдэглэж байна. 1939 онд Зөвлөлтийн армийн тусламжтайгаар Японы 6 дугаар армийг бут цохисон монголын ард түмэн ч Эх орны аугаа их дайн эхэлсэн эхний өдрөөс буюу 1941 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 1945 оны ялалтын өдөр хүртэл найрамдалт хөрш Оросын ард түмэнтэй сэтгэл санаа нэг байж, эх орноо фашистын булаан эзлэгчдээс авран хамгаалахад нь бүх талаар тусалж, өөрт байгаа бүхнээ фронтод зориулж ирсэн билээ. Энэ тухай Монгол улсын түүхэнд “Зөвлөлтийн эх орны дайн эхэлсэн тэр өдөр МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчид, БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид, Ардын Сайд нарын зөвлөлийн хамтарсан яаралтай хуралдаан болж, фашист түрэмгийлэгчдийн үйлдлийг эрс жигшин эсэргүүцэж байгаагаа илэрхийлээд Монгол-Зөвлөлтийн 1936 оны харилцан туслалцах протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэх, найрамдалт ЗХУ-д бүх бололцоогоор туслах шийдвэр гаргав”³, “БНМАУ хэдийгээр зөвлөлт эх орны дайнд шууд оролцоогүй боловч, Зөвлөлтийн фронтын гүн ар тал болжээ”⁴ хэмээн бичигдэн үлджээ.

1. Монголын ард түмний зүрх сэтгэлд Орос орон, Оросын ард түмэн хэзээнээс ойр дотно байсан билээ. Хүнд хэцүү цаг үед өөрсдийн түшиг тулгуур болсон ганц улс, хүн ард бол ЗХУ, оросын ард түмэн гэдгийг монголчууд мэдэрч, ах хэмээн хүндэтгэж халуун дотноор хандаж ирсний нэгэн нотолгоо бол 1940-өөд оноос эхлэн хүүхдэдээ “Орос” гэдэг нэр олонтоо өгөх болжээ. Монгол хүний нэрийн санд *Орос* (56), *Оросоо* (169), *Орсоо* (382) байна. Өөрөөр хэлбэл энэхүү 607 хүн “Орос хүн” гэсэн утга бүхий нэртэй байна. Түүгээр ч үл барам *Оросмаа* (6), *Оросхаан* (6), *Оросоохүү* (5), *Оросхүү* (4), *Бат-Орос* (3), *Оросбат* (2), *Ороссүх* (2), *Орсообаатар* (2), *Оросбаяр* (1), *Оросгомбо* (1), *Оросдаваа* (1), *Оросдагва* (1), *Оросдорж* (1), *Төмөр-Орос* (1), *Оросжаргал* (1), *Оросрэнцэн* (1), *Оросцэрэг* (1), *Оросоохүүхэн* (1), *Санжаа-Орос* (1), *Сүх-Орос* (1) гэсэн 18 нэрэнд орос гэдэг үг орж цөөн давтамжит нийлмэл нэр үүсгэсэн байна.

1917 оны Октябрийн хувьсгалын дараа 1922 оны 12 дугаар сарын 30-наас Орос, Украин, Беларусс зэрэг улсуудын бүрэлдэхүүнтэйгээр Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс буюу СССР (Союз Советских Социалистических республик гэдэг үгийн товчилсон бичлэг) “байгуулагдсан түүхтэй. Үүнээс хойш манай хойт хөрш Орос улсыг 1990 он хүртэл Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс буюу Зөвлөлт Холбоот Улс гэж нэрлэх болсон билээ. Монголчуудын Зөвлөлт Улс хэмээн нэрлэдэг энэ улс Ази Европ хоёр тивийг дамнасан 22.4 сая хавтгай дөрвөлжин километр газар нутагтай, бүрэлдэхүүнд нь 15 Бүгд Найрамдах улс, 20 Автономит улс, 8 Автономит муж, 10 Автономит тойрог, 128 муж хязгаартай, 100 гаруй үндэстний 268 сая хүн амтай асар том гүрэн⁵ байлаа. Монгол хүний нэрийн санд СССР гэдэг нэр 2 байгаа ба энэ нэрийн монгол дуудлага болох *Сэсээр* (135), *Сэсээрболд* (1), *Сэсээрбуд* (1), *Сэсээрдагва* (1), *Сэсээрдорж* (1), *Сэсээрмаа* (1), *Сэсээрхаан* (1), *Сэсээрхүү* (1), *Сэсээрцогт* (1), *Сэсэр* (4), *Сэсэрмаа* (1) байна. Эдгээр 150 хүний нэр бол бүгд 1940-50 оны үед монгол хүний нэрийн санд орж ирсэн бөгөөд түүнээс өмнө, хойно бараг тохиолдохгүй байна. Энэ үед монголчууд Орос улс, Оросын улаан арми гэж бараг ярихгүй, Сэсээр улс, Сэсээрийн улаан арми, Зөвлөлтийн улаан арми хэмээн хэлэлцдэг байсан гэдэг. Түүний тусгал болсон эдгээр нэртэй хүмүүс одоо ч бидний дунд ажиллаж амьдарч байна.

³ Монгол улсын түүх. (2003) УБ., 230-р тал

⁴ Монгол улсын түүх. (2003) УБ., 231-р тал

⁵ Советский энциклопедический словарь. (1985) Москва.

2. Дайны жилүүдэд Орос болон Зөвлөлтийн цэргийн зүтгэлтэн, нэрт жанжнуудын нэрийг хүүхдэдээ өгөх нь цөөнгүй байжээ. Ялангуяа ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, Монгол улсын баатар Георгий Константинович Жуковын (1896-1974) нэртэй хүн манай олон аймагт тохиолддог. Тухайлбал бидний судалгаагаар Жуков нэртэй 48 хүн байгаагийн эхнийх нь 1932 онд төрсөн бөгөөд 1939-60 онд ихэнх нь төрсөн байна.

Г.К.Жуков бол Зөвлөлт Холбоот Улсын баатар цолыг дөрвөн удаа хүртсэн цорын ганц хүн бөгөөд 1939 онд Халхын голд Япон цэргийн 6 дугаар армийн томоохон бүлэглэлийг бүслэн бүрмөсөн бут цохих операцыг гарамгай удирдаж ЗХУ-ын баатар цолыг анх удаагаа хүртсэн, Монгол улсын баатар, монголчуудын сайн мэддэг цэргийн нэрт жанжин билээ. Тэрээр 1945 оны 5 дугаар сарын 8-нд Берлинд фашист Германы зэвсэгт хүчин үг дуугүй бууж өгөхөөр гарын үсэг зурсан актыг Зөвлөлтийн цэргийн Ерөнхий дээд командлалын нэрийн өмнөөс хүлээн авах, 1945 оны 6 дугаар сарын 24-нд Москвагийн Улаан талбайд хийсэн Аугаа их эх орны дайны Ялалтын парадыг хүлээн авах хүндэтгэлийг хүлээж явжээ. Түүнчлэн ЗХУ-ын хоёр удаагийн баатар, Социалист хөдөлмөрийн баатар, ЗСБНХУ-ын Батлан хамгаалах ардын комиссариатын даргаар олон жил ажилласны дээр Эх орны дайны жилүүдэд Зөвлөлтийн Батлан хамгаалах улсын хорооны даргаар ажиллаж байсан, зөвлөлтийн цэргийн нэрт зүтгэлтэн, ЗХУ-ын маршал Климент Ефремович Ворошилов (1881-1969)-ын нэр *Ворошилов (9), Ворошилов (3), Ворошилов (2), Ворошилов (2), Ворошилов (1), Ворошилов (1)* гэсэн өөр өөр бичлэгтэйгээр 1957-60 онд төрсөн 18 хүний нэр болон хэрэглэгдэж байна. Маршал Ворошиловт зориулан монголчууд дуу зохиосон бөгөөд уг дуунд:

.... Хүрэн халзан тоомсгоороо

Хүрээд ирсэн Ворошилов

Хүчтэй олон цэргүүдээ

Ганцаараа командалсан Ворошилов ... хэмээн дуулдаг байсан.

Мөн ЗХУ-ын маршал, ЗХУ-ын гурван удаагийн баатар, Семен Михайлович Буденный (1883-1973)-н нэрээс 1940-1950 онд төрсөн *Буденин* гэсэн нэртэй 3 хүн байна. Цаашилбал, Оросын цэргийн нэрт жанжин, генераллиссимус Александр Василевич Суворов (1729-1800)-ын нэрээр нэрлүүлсэн 10 хүн 1950-1958 онд төрсөн байна. Эдгээр нэрээс гадна ЗХУ-ын коммунист нам, Зөвлөлт төрийн удирдагч, генераллиссимус Иосиф Виссарионович Сталин (1879-1953)-ы нэртэй 2 хүн 1940-өөд онд, Зөвлөлтийн иргэний дайны баатар Василий Иванович Чапаев (1887-1919) –ын нэртэй 4 хүн 1937, 1939, 1945 онд, Зөвлөлтийн нам, төр, цэргийн зүтгэлтэн, цэргийн онолч Михайл Васильевич Фрунзе (1885-1925)-ийн нэртэй 4 хүн 1950-иад онд, 1938 оноос эхлэн Эх орны дайны жилүүдэд ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн тэргүүлэгчдийн даргаар ажиллаж байсан ЗХУ-ын нам, төрийн нэрт зүтгэлтэн, социалист хөдөлмөрийн баатар Михайл Иванович Калинин (1875-1946)-ы нэртэй 13 хүн 1939-1955 онд тус тус төрсөн байна⁶. Мөн эх орны дайны үеэр нэр нь алдаршсан Зөвлөлтийн партизан охин, ЗХУ-ын баатар Зоя Космодемьянская (1923-41)-гийн нэртэй холбоотой *Зооёо (7), Зояо (4), Зоёо (2), Зое (1), Зоёобаатар (1), Алтанзоёо (2), Дэлгэрзояа (1)* гэсэн нэрээс гадна 1941-45 онд ЗСБНХУ-ын Сайд нарын зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга, Батлан хамгаалах улсын хорооны орлогч дарга, 1957-60 онд ЗХУ-аас БНМАУ-д суух онц бөгөөд бүрэн эрхт элчин

⁶ Сувд Ц. (2007) XX зууны монгол хүний нэрийн сан дахь түүхэн хүмүүсийн нэрийн тухай. –“МОНГОЛ СУДЛАЛ”. МУИС. МХСС. Боть 285 (ХХҮП). УБ., 84-98-р тал.

сайдаар ажиллаж байсан Зөвлөлтийн нам, төрийн зүтгэлтэн В.М.Молотовын (1890-1986) нэрийг 1938-60 онд төрсөн 14 хүнд өгчээ.

3. 1940-өөд оноос монгол хүний нэрийн санд цэрэг арми, зэр зэвсгийн холбогдолтой олон нэр орж ирсэн байна. Жишээлбэл: цэрэг гэсэн утгатай *Солдат* гэдэг нэр (9), хошууч гэсэн утгатай цэргийн цолоор нэрлэсэн *Майор* (6), *Моёор* (1), дарга, захирагч гэсэн утгатай *Командир* (1), Цэргийн дээд цол *Генерал* (2), *Маршал* (3), *Адмирал* (1) гэх мэтийн цэрэг армийн бие бүрэлдэхүүний цол, албан тушаалаар нэрлэсэн нэр тохиолдож байна. Мөн *Арми* (зэвсэгт хүчин) 3, *Штаб* (цэргийн захирах, командлалын байгууллага) 2, *Отряд* (анги, баг) 7, *Застав* (харуул) 2, *Фронт* (байлдааны талбар, дайн шугам) 2 гэх мэтийн цэрэг армийн зохион байгуулалттай холбоотой нэр томъёо; *Слава* (алдар, алдар цуу) 7, *Марш* (аян, цэргийн алхаа) 3, *План* (зураг, төлөвлөгөө) 7, *Точка* (цэг) 1, *Точно* (нарийн, ёсоор, цагт нь) 1, *Война* (дайн) 1, *Команд* (тушаал, захирах) 1, *Шинель* (цэргийн цэмбэн дээл) гэх мэтийн цэрэг дайны ажил хэргийн зарим нэр томъёо, *Винтов* (5), *Танк* (2), *Танх* (2) *Магазин* (бууны хүхээ) 1, *Гарнаад* (2), *Галабор* (калибр), *Бирдаан*, *Нагаанбуу* (револьвер наганы нэр), *Маабазар* (маузер бууны нэр) гэх мэтийн зэвсэг техникийн олон нэр орос хэлнээс орж ирснээс гадна цэрэг зэвсэг, армийн холбогдолтой Батцэрэг, Цэрэгмаа, Зэвсэг гэх мэт монгол нэр ч бас байдаг.

4. Дэлхийн II дайны дараахнаас, тодруулбал 1940-өөд оны сүүлч, 50-иад оны эхнээс монголчуудын дунд орос хүний нэр ихээхэн дэлгэрсэн нь XX зууны монгол хүний нэрийн нэгэн онцлог юм⁷. Энэ үзэгдэл зөвхөн монголд төдийгүй дэлхийн II дайны эцсээс эхлэн Европын бүх орнууд, АНУ, Латин америкийн орнууд, Австралид орос нэрийг маш их сонирхох болжээ⁸. Энэ нь фашист германы булаан эзлэгчдийн аюулаас хүн төрөлхтнийг аварсан зөвлөлтийн ард түмний түүхэн гавьяатай холбоотой нь мэдээжийн хэрэг юм. Орос гаралтай нэр монголчуудын дунд өргөн хүрээнд түгээмэл тархаж чадаагүй учраас олон давтамж бүхий түгээмэл нэрийн дунд төдий л олон тохиолдохгүй бөгөөд харин цөөн давтамжтай түгээмэл бус нэрийн дотор ихэнх нь тохиолддог онцлогтой. Нөгөө талаар орос болон оросоор дамжин европын бусад хэлнээс орж ирсэн нэр нь төвд, санскрит нэрийн адил олон зуун жилийн уламжлалгүй, зөвхөн XX зууны дунд үеэс л нэг хэсэг хугацаанд орж ирсэн монгол хэлний үгийн сан, хэлзүйн орчинд төдийлөн дасч зохицоогүй, харь хэлний гаралтай нэр гэдэг нь илэрхий мэдэгдэж байдаг.

5. 1939 оны Халх голын дайн, 1945 оны чөлөөлөх дайнд баатарлаг гавьяа байгуулан БНМАУ-ын баатар цолоор шагнагдсан эрэлхэг дайчдын нэрээр нэрлүүлсэн хөвгүүд энэ үед цөөнгүй төрсөн юм. Тухайлбал, БНМАУ-ын баатар Лодонгийн Дандар (1915-1986) –ын нэрээс үүссэн *Дандарбаатар* нэртэй 35 хүн 1952-1999 онд, БНМАУ-ын баатар Цэндийн Олзвойн нэрээс үүсэлтэй *Олзвойбаатар* нэртэй 21 хүн 1950-1994 онд төрсөн бөгөөд *Дугаржавбаатар* гэдэг нэртэй хүн 1 байгаа нь Халх голын дайны үед “Монгол Чапаев” хэмээн алдаршсан морин цэргийн залуу дарга, БНМАУ-ын баатар Чойн Дугаржавын нэрээс үүсэлтэй ажээ. *Хошойбаатар* гэдэг нэр 2 байгаа нь БНМАУ-ын хошой баатар, Халх голын дайны Монголын армийн ерөнхий командлагч, маршал Х.Чойбалсантай холбогдоно. Халх голын дайнд амь эрсэдсэн 90 баатрын хөшөө Дорнод аймгийн Халхгол сумын нутагт сүндэрлэн байдаг. Энэ үйл явдлын гэрч болох

⁷⁾ Сэржээ Ж. (2006), XX зууны монгол хүний нэрийн зарим онцлог. “Ономастическое пространство и национальная культура” –“МАТЕРИАЛЫ МЕЖДУНАРОДНОЙ НАУЧНО-ПРАКТИЧЕСКОЙ КОНФЕРЕНЦИИ” 14-16 сентября. Улан-удэ., 98-103-р тал.

⁸⁾ Ономастика: Типология и стратиграфия. (1988) Москва, 233-р тал.

Ерэнбаатар хэмээх нэртэй хүн 19 байна. Тухайлбал, БНМАУ-ын баатар Лувсанцэрэнгийн Аюушийн нэрээс үүсэлтэй *Аюушбаатар* нэртэй 43 хүн 1947-2000 онд тус тус төржээ. Дашрамд дурдахад Аюушбаатар нэртэн нөгөө хоёр нэрээсээ олон байгаа нь, тэдний зарим нь БНМАУ-ын хөдөлмөрийн баатар саальчин Аюушийн нэрээр нэрлэгдсэн байх боломжтой оршино. Дэлхийн II дайны дараагаас монгол хүний нэрийн санд монгол хэлний үгээс бүтсэн зарим шинэ нэрс орж ирсэн юм.

Энэ жил 70 жилийн ойг нь ёслол төгөлдөр тэмдэглэж байгаа Эх орны аугаа их дайны ялалт бол хүн төрөлхтөний түүхэнд, түүний дотор монголын түүхэнд гүн ул мөрөө үлдээсэн түүхэн үйл явдал байлаа. Энэ ялалт, дэлхийн дайны төгсгөлийг хүн төрөлхтөн нийтээрээ баяр хөөртэй хүлээн авсан билээ. Энэхүү ялалтын үеэр төрсөн хүүхдэд “Ялалт”, (Ялалт нэртэй анхны хүүхэд 1944.7.5-нд төрсөн байдаг) *Ялалтбаяр*, *Батялалт*, *Мөнхялалт*, *Төгсялалт*, *Энхялалт* гэх мэт ялалт гэдэг үг оролцсон 321 нэр монгол хүний нэрийн санд байна: Мөн *Бидялав* нэртэй хүн ч бүртгэгдсэн байдаг.

6. 1939 оны Халх голын дайнаас эхлэн 1945 оны чөлөөлөх дайныг дуустал 6 жил шахам хугацаанд дайны хүнд бэрх үеийг эд хөрөнгө, сэтгэл санаа, бие сэтгэлээрээ даван туулсны дараа энх тайван цаг ирж, амар төвшин амьдрах болсон 1940-өөд оны сүүлчээс эхлэн 1950-1960-аад оноос “Энх” гэдэг нэртэй хүн асар олон болсон юм. Тухайлбал монгол хүний нэрийн санд *Энх* гэдэг үг эхэнд нь орж 123 нийлмэл нэр үүсгэж байгаагийн⁹ дотор 1000 –аас дээш давтамжтай *Энхтуяа* 9358, *Энхжаргал* 8012, *Энхбаяр* 6970, *Энхцэцэг* 6453, *Энхбат* 5143, *Энхболд* 5000, *Энхтайван* 4172, *Энхтөвшин* 3521, *Энх-Амгалан* 3282, *Энхтөр* 3272, *Энхсайхан* 2755, *Энхмаа* 2733, *Энхчимэг* 2343, *Энхзаяа* 2338, *Энхтуул* 1787, *Энхзул* 1472, *Энхжсин* 1400, *Энхээ* 1125 гэх мэтийн 18 нэр бүртгэгдсэн байна¹⁰. Эдгээр нэр дайны дараа бүгдээрээ нэгэн зэрэг бий болоогүй нь тодорхой бөгөөд нэр тус бүрийн давтамжийн өсөлт бууралтаас ажиглахад сонирхолтой үр дүн харагдана. Тухайлбал хамгийн олон буюу 9358 хүнийг нэрлэж байгаа *Энхтуяа* гэдэг нэр 1930-39 онд 8 байсан бол 1940-49 онд 114, 1950-59 онд 1297, 1960-69 онд 3478 болж өссөн бөгөөд цаашдаа 1970-79 онд 2145, 1980-89 онд 1635, 1990-99 онд 679 болж буурсан байна. 4172 давтамжтай *Энхтайван* гэдэг нэр 1940-49 онд 16, 1950-59 онд 780, 1960-69 онд 1153 болж өсөөд, цаашдаа 1970-79 онд 875, 1980-89 онд 1003, 1990-99 онд 344 болон цөөрчээ. Энэхүү “Энх”-ээр эхэлсэн 18 нэрийн давтамжийн судалгаанаас үзвэл, *Энхтуяа*, *Энхжаргал*, *Энхбаяр*, *Энхболд*, *Энхтайван*, *Энхтөвшин*, *Энх-Амгалан*, *Энхтөр*, *Энхмаа* гэсэн нэрс 1940-өөд оноос монгол хүний нэрийн санд орж ирсэн бол, *Энхцэцэг*, *Энхбат*, *Энхсайхан*, *Энхчимэг*, *Энхзаяа*, *Энхтуул* гэдэг нэрс 1950-иад оноос, *Энхзул*, *Энхжсин* гэдэг нэр 1960-аад оноос тус тус монгол хүний нэрийн санд орж ирсэн байна. Тэгвэл дээрх нэрсийн хамгийн их тархсан үеийг авч үзвэл *Энхтуяа* 1960-69 онд 3478, *Энхжаргал* 1970-79 онд 2139, 1980-89 онд 2304, *Энхбаяр* 1980-89 онд 2190, *Энхцэцэг* 1980-89 онд 2125, *Энхбат* 1980-89 онд 1614, *Энхболд* 1970-79 онд 1310, 1980-89 онд 1470, *Энхтайван* 1960-69 онд 1153, *Энхтөвшин* 1970-79 онд 972, *Энх-Амгалан* 1980-89 онд 943, *Энхтөр* 1980-89 онд 981, *Энхсайхан* 1980-89 онд 844, *Энхмаа* 1980-89 онд 883, *Энхчимэг* 1980-89 онд 983, *Энхзаяа* 1980-89 онд 877, 1990-99 онд 981, *Энхтуул* 1980-89 онд 601, *Энхзул* 1980-89 онд 640, *Энхжсин* 1990-99 онд 1189, *Энхээ* 1960-69 онд 438 төрсөн байна. Үүнээс үндэслэн, *Энхтуяа*, *Энхтайван*, *Энхээ* гэдэг нэрсийг 1960-аад оны; *Энхжаргал*, *Энхболд*, *Энхтөвшинг* 1970-аад оны; *Энхжаргал*, *Энхбаяр*, *Энхцэцэг*,

⁹⁾ Сэржээ Ж. (2010), Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн судалгаа. УБ., 70-р тал.

¹⁰⁾ Сувд Ц. (2010), Хорьдугаар зууны монгол хүний нэр. УБ., 192-203-р тал.

Энхбат, Энх-Амгалан, Энхтөр, Энхсайхан, Энхзаяа, Энхтуул, Энхзул гэдэг нэрсийг 1980-аад оны; *Энхжин* гэдэг нэрийг 1990-ээд оны нэр хэмээн үзэх боломтой юм. Зөвхөн энд дурдсан 18 нэр монголын 71136 хүнийг нэрлэж байгаа нь дайны дараа энх тайван, амар амгалан цаг ирснийг монголын ард түмэн хэрхэн хүлээж авсныг яруу тодорхой нотолж байгаа хэрэг бус уу. Үнэхээр өнөөдөр Монгол улсын Их Хуралд суудалтай 5 намын дөрвийнх нь дарга *З.Энхболд, М.Энхболд, Н.Энхбаяр, М.Энхсайхан* нэртэй, бас УИХ-ын гишүүн *Н.Энхболд, Ө.Энхтөвшин* гэх мэтчилэн бидний эргэн тойронд олон мянган “ЭНХ”-үүд ажиллаж амьдарч байна.

НОМЗҮЙ

1. *Монголын нэвтэрхий толь*. УБ., 2000
2. *Монгол улсын түүх*. Таван боть. Ү боть, УБ., 2003
3. *Ономастика: Типология и стратиграфия*. Москва., 1988
4. *Советский энциклопедический словарь*. Москва., 1985
5. Сувд Ц. *XX зууны монгол хүний нэрийн сан дахь түүхэн хүмүүсийн нэрийн тухай*. МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлал” ЭШБ. Боть ХХҮII (285), УБ., 2007
6. Сувд Ц. *Монгол хүний нэрэнд байгаа орос гаралтай нэрийн судалгааны зарим үр дүн*. МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлал” ЭШБ. Боть ХХҮIII (294), УБ., 2008
7. Сувд Ц. *Хорьдугаар зууны монгол хүний нэр*. УБ., 2010
8. Суперанская А.В. *Общая теория имени собственного*. Москва., 1973
9. Сэржээ Ж. *XX зууны монгол хүний нэрийн зарим онцлог. “Ономастическое пространство и национальная культура”* Материалы международной научно-практической конференции 14-16 сентября 2006. Улан-удэ., 2006
10. Сэржээ Ж. *Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн судалгаа*. УБ., 2010

ABSTRACT

Historical events that the Soviet Red Army crushed German fascism in the Second World War and the Soviet and Mongolian joint armies broke up the Japanese invaders in the battle of Khalkh Gol in 1939 and war for Liberation in 1945, left deep memories to the nation's hearts. Therefore, a large number of human names which became evidence related to war and battle are still being used among Mongolians. For example, nation's name such as *Seseer* (Mongolians calls USSR as a Seseer), *Oros (Russia)*, *Orsoo*, military general's name: *Zhukov*, military position's name: *Marshall*, weapon's name: *Tank*, *Vintov* and name refers to the military organization: *Otryad* (it means 'brigade'), *Zastav* (military point) and *Army*. We have proved these on the basis of evidence. Moreover, we revealed many names which became symbol for arrival of peace after a war victory. Some of them are: *Yalalt* (victory), *Bat-Yalalt* (solid victory), *Enkh* (tranquility) and *Enkh-taivan* (peace).